



## Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Отгонтэнгэр их сургууль

Хөтөлбөрийн нэр: Гадаад хэлний орчуулга /Хятад хэл/

Индекс: D023101

Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Ундрах

Гишүүд: Б.Оюунчимэг  
Л.Чойжилмаа

Он сар өдөр: 2021-05-31

## Агуулга

<b>Товчилсон үгийн тайлбар</b> .....	4
<b>I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт</b> .....	5
<b>II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга</b> .....	6
<b>III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт</b> .....	7
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт .....	7
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа .....	10
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл .....	12
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт .....	14
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа .....	19
Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа .....	23
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт .....	26
<b>IV. Уулзалтад оролцогчдын нэрс</b> .....	33
I. Багш нарын нэрс .....	33
II. Оюутнуудын нэрс .....	33
III. Ажил олгогчдын нэрс .....	34
IV. Төгсөгчдийн нэрс .....	34
<b>V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал</b> .....	35
<b>ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр</b>	
<b>ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр</b>	

## Товчилсон үгийн тайлбар

ОТИС	Отгонтэнгэр Их сургууль
МУИС	Монгол Улсын Их сургууль
МУБИС	Монгол Улсын Боловсролын их сургууль
ИС	Их сургууль
ХИС	Хүмүүнлэгийн ухааны Их сургууль
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн Их сургууль
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард улс
ӨҮТ	Өөрийн үнэлгээний тайлан
PLO	Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн
CLO	Хичээлийн суралцахуйн үр дүн
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
СХССТ	Сурган хүмүүжүүлэх сэтгэл судлалын тэнхим
ЗХШҮА	Захиргаа хяналт, шинжилгээ үнэлгээний алба
УЗ	Удирдах зөвлөл
ЭСЯ	Элчин сайдын яам

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	Отгонтэнгэр их сургууль	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Гадаад хэлний орчуулга /Хятад хэл/ Translation and Interpretation/Chinese/	
<b>Индекс</b>	023101	
<b>Шинжээчид</b>	Шинжээчийн багийн ахлах: Д.Ундрах - Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Ази судлалын тэнхимийн дэд профессор, доктор Гишүүд: Б.Оюунчимэг - Хүмүүлэгийн ухааны Их сургуулийн хятад хэлний багш, доктор Л.Чойжилмаа - Шинжлэх ухаан технологийн Их сургуулийн Гадаад хэлний сургуулийн Ази судлалын тэнхимийн дэд профессор, доктор	
<b>БМИҮЗ-ийн Мэргэжилтэн</b>	БМИҮЗ-ийн Магадлан итгэмжлэл хариуцсан ахлах шинжээч Б.Мядагмаа	
	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b>
		2021-05-28
	08:45	Шинжээчийн багийн уулзалт
	09:00-09:10	Нээлт
	9:10-9:55	БМИҮЗ-ийн шинэ журам, үйл ажиллагаа болон шинжээчдийн танилцуулга
	09:55-10:10	Отгонтэнгэр их сургууль, хөтөлбөрийн товч танилцуулга.
	10:10-11:10	Сургуулийн сургалт орчинтой танилцах.
	11:10-13:00	Хөтөлбөрийн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцана.
	14:00-15:30	Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцана
	15:30-16:30	Ажил олгогчидтой хийх уулзалт
	16:30-17:00	Шинжээчийн багийн уулзалт, хэлэлцүүлэг
		2021-05-29
	9:00-11:00	Шинжээчийн багийн уулзалт, хэлэлцүүлэг
	11:00-11:50	Оюутнуудын төлөөлөлтэй хийх уулзалт
	12:00-12:50	Багш нарын төлөөлөлтэй хийх уулзалт
	13:00-14:00	Төгсөгчийн төлөөлөлтэй хийх уулзалт
	14:00-15:00	Шинжээчийн багийн нэгдсэн дүгнэлт
	15:00-16:00	Шинжээчийн баг урьдчилсан дүгнэлтээ танилцуулна
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	БМИҮЗ-өөс эрхлэн мөрдүүлж буй Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд мөрдөх заавар, журмууд, БСШУ-ны Сайдын 2016 оны 02 сарын 19-ний өдрийн А/53 тушаал, Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайлан, Шинжээчийн үнэлгээний тайлан, холбогдох бусад заавар, эрхийн баримт бичиг, БМИҮЗ-ийн Ажлын албаны захирлын 2020 оны 02 сарын 06-ний өдрийн 4/28 тушаал.	

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Отгонтэнгэр Их сургууль “Хятад хэлний орчуулагч-багш” хөтөлбөрөөр анх 1991 онд элсэлт авч, үндэсний хэмжээний боловсон хүчин бэлтгэж эхэлсэн. Хөтөлбөр Хятад хэлний багш-орчуулагч мэргэжлээр нээгдэж байсан бөгөөд хэрэгжсэн 30 жилийн хугацаанд хөтөлбөрийн зорилго, зорилтоо дэлхийн болон өөрийн орны гадаад хэлний хөгжлийн чиг хандлага, сүүлийн үеийн аргазүйтэй уялдуулан боловсронгуй болгож сайжруулж иржээ.

Тус хөтөлбөр 2014 онд анх магадлан итгэмжлэгдсэн бөгөөд 2021 онд хоёр дахь удаагаа магадлан итгэмжлэх гэж байна. Хөтөлбөрийн зорилго нь аман болон бичгийн өндөр ур чадвартай, судалгаа шинжилгээ хийх арга барил эзэмшсэн, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвартай, мэргэжлийн өндөр ёс зүйтэй мэргэжилтэн бэлтгэхэд оршиж байна.

Анх ОТИС байгуулагдсан үеэс Хятад хэлний-орчуулагч багш мэргэжлээр оюутан элсүүлсэн байна. 1995 онд “Дорно дахины хэлний” тэнхим байгуулагдаж, 1998-1999 оны хичээлийн жилд “Ерөнхий эрдмийн тэнхим”, 2000-2001 оны хичээлийн жилд “Хэл шинжлэл, дорно дахины хэлний тэнхим”, 2005 оноос “Дорно дахины хэлний тэнхим”, 2019 оноос “Дорно дахин агаарын тээврийн үйлчилгээний тэнхим” нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус тэнхимд

1. Ц.Баярмаа /2017 оноос/
2. Ц.Булган /2017 оноос/
3. Жон Кёжин /2017 оноос/
4. Ө.Нарантуяа /2017 оноос/
5. Э.Номин /2014 оноос/
6. Л.Хишигжаргал /2017 оноос/ нар тус тус ажиллаж байна.

2020-2021 оны хичээлийн жилд тус тэнхим боловсролын докторын зэрэгтэй 3 багш, докторант 1 багш, магистрын зэрэгтэй 2 багштай үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийгмийн хэрэгцээ шаардлага, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хөрвөх чадвартай, чадварлаг боловсон хүчин мэргэжлийн стандартын дагуу бэлтгэн боловсруулахад хөтөлбөрийн зорилго, агуулга болон аргазүйг байнга шинэчлэн боловсруулж ирсэн бөгөөд сургалтын төлөвлөгөөг 2017, 2019 онуудад шинэчлэн боловсруулж сургалтад нэвтрүүлжээ.

2014 оны магадлан итгэмжлэлээр ажилласан шинжээчийн багийн өгсөн зөвлөмжийн дагуу сайжруулалт хийж ажиллаж байна.

Үүнд:

№	ЗӨВЛӨМЖ	САЙЖРУУЛАЛТ
1	ЭША-ын зардлыг нэмэх, доктор багшийн тоог нэмэгдүүлэх	2015 оноос хойш жил бүр 2-3 багш докторын зэрэг хамгаалсан
2	Маркетингийн үйл ажиллагааг сайжруулах	2015 оноос маркетингийн бие даасан албатай болсон
3	Ном сурах бичгийг хэлэлцүүлж хэвлэх, зохиогчийн эрх авах	Жил бүр эрдмийн зөвлөлөөр хэвлүүлэх ном сурах бичгийн

		хэлэлцүүлгийг хийж зөвшөөрөл олгодог
4	Залуу багш нарыг судалгааны ажилд татан оруулах	Нийгмийн судалгааны төв байгуулагдсан. Гадаадын судалгааны төслийн сургалтыг зохион байгуулсан
5	Сургалтын мэдээллийн нэгдсэн программыг сайжруулах	Сургалтын харилцааг бүрэн зохицуулах ONEMISS мэдээллийн системийг ашиглаж байна
6	Төгсөгчдийн ажил эрхлэлтийг сургуулиас анхаарах	Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв байгуулагдсан
7	Цахим сургалтыг сайжруулах	2018 оноос цахим сургалтын дэд бүтцийг хөгжүүлж ирсэн. Цахим сургалт явуулах цогц систем бүрдсэн.

Хөтөлбөр хэрэгжсэн 30 жилийн хугацаанд 378 оюутан төгссөнөөс 25 орчим хувь нь БНХАУ-ын их, дээд сургуульд тэтгэлгээр суралцаж байгаа нь онцлог болж байгаа юм.

### III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

#### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

#### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

##### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн төлөвлөлтийг PDCA, мэргэжлийн хэрэгцээ шаардлагыг тандах зорилгоор STEEP шинжилгээг тус тус хийж хүснэгтээр хавсаргасан.
- Хөтөлбөрийн харьцуулсан судалгааг ХИС-ийн “Гадаад хэлний боловсрол, хятад хэл”, МУИС-ийн Гадаад хэлний орчуулга бакалаврын хөтөлбөртэй харьцуулж, өөрийн онцлог, давуу талд дүн шинжилгээ хийсэн байна. Мөн БНХАУ-ын Бээжингийн хэлний Их сургууль, Хонгконгийн Жинхуй их сургуулийн гадаад хэлний орчуулагчийн Цаашид гадаад, дотоодын илүү олон хөтөлбөртэй харьцуулжээ,
- Хөтөлбөрийн мэргэжлийн суурь хичээлүүдийн багц ижил төстэй гадаад дотоодын их дээд сургуулиудын хөтөлбөрийн хичээлүүдийн агуулгатай нийцэж байна.
- Мэргэжлийн боловсролын хөтөлбөр, хичээлийн хөтөлбөр боловсруулах удирдамжийн дагуу хөтөлбөрөө боловсруулсан.

#### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

##### Туршлага:

- Хөтөлбөрийн оролцогч талуудаас тодорхой давтамжтайгаар олон шалгуур асуултын дагуу санал асуулгыг сүүлийн таван жилийн турш тогтмол авч тэдний саналд шинжилгээ хийж үр дүнг хөтөлбөр сайжруулалтдаа нэмдэг.
- Тухайн мэргэжлээр жил бүр тодорхой тооны элсэгч элсэж байгаа нь зах зээлийн эрэлт хэрэгцээ байгааг харуулж байгаагийн дээр төгсөгчид зөвхөн багшийн ажилд орох биш, өөр ажлын байранд тэнцэн ажиллаж байгаа нь энэ хөтөлбөрийн төгсөгчийн хөрвөх чадвар өндөр байгааг нотолж байна.
- Хятад хэлний орчуулагчийн эрэлт хэрэгцээ Дотоодын бусад сургуулийн ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулахад орчуулгын хичээлийг нийт 22 кредит цаг үздэг, сургалт явуулдаг зэрэг нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд онцлог нь тал болж байна.

##### Анхаарах асуудал:

- Гадаадын ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгааг хийхдээ зөвхөн БНХАУ-ын сургуулиудын англи франц хэлний орчуулагч бэлддэг хөтөлбөртэй харьцуулсан нь хятад хэлний орчуулагч бэлдэх онцлогийг гаргахад учир дутагдалтай байна.

#### **Зөвлөмж:**

- Европ, Америк, БНХАУ-аас бусад Азийн их дээд сургуулиудын ижил төстэй, хятад хэлний орчуулагч бэлддэг хөтөлбөрүүдтэй харьцуулж үзэх шаардлагатай.
- Зөвхөн хичээлийн нэр төрлийн түвшинд бус, хичээлийн хөтөлбөрийн агуулгыг харьцуулсны үндсэн дээр сургалтын хөтөлбөрөө улам сайжруулах тал дээр судалгаа хийх шаардлагатай байна.

### **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн зорилгоо сургуулийн эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөний зорилтуудтай уялдуулан тодорхойлсон.
- Хөтөлбөрийн зорилго зорилтыг тодорхойлж хөтөлбөрөөр эзэмшүүлэх мэдлэг чадвар болон хөтөлбөрийн зорилго зорилтууд хоорондын уялдаа, холбоог гаргасан.
- Хөтөлбөрийн зорилгын дагуу зорилтуудыг дэвшүүлж ажилладаг ба хөтөлбөрөөр эзэмших суурь мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлсон байна. Хөтөлбөрийн зорилго, зорилтууд болон эзэмших мэдлэг, чадварын хоорондын уялдаа холбоог Course Learning Outcomes загвараар тодорхойлсон нь сайшаалтай байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Туршлага:**

- 2019 онд орчуулгын хичээлүүдийн хөтөлбөрийн агуулгын давхардлыг арилгаж, агуулгыг сайжруулсан.
- Төгсөгчидтэй эргэх холбоо сайтай, дахин сургалт явуулдаг.

### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.



### **Илрэл нотолгоо:**

- 2017 онд шинэчлэн хэрэгжүүлж байсан хөтөлбөрөө 2019-2020 нэмж сайжруулан баталж, хөтөлбөрийг сургалтад хэрэглэж байгаа.
- Сургуулийн хэмжээнд нэгдсэн нэг стандартаар хичээл тус бүр дээр хичээлийн хөтөлбөр боловсруулдаг.
- Хичээлийн хөтөлбөрийг тайланд хавсаргасан.
- Хичээлийн хөтөлбөрийг тухайн хичээлийг хариуцсан мэргэжлийн тэнхимээс эрх олгосон багш нар боловсруулж, хөтөлбөрийн хороо шалган баталгаажуулдаг.
- 2019 онд хөтөлбөрөө шинэчлэхдээ хичээлийн агуулгын давхцалыг багасгаж, хичээл хоорондын зохистой залгамж холбоо, оюутан хичээл, багшийг сонгох боломжийг гаргажээ.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл:**

- Оюутны дадлагыг “Genius” орчуулгын товчоо, уран зохиолын баг, кино орчуулгын багт тус бүрд хувааж гүйцэтгэдэг. хамт олны дунд орж ажиллах, багаар ажиллаж сурахад нь ач холбогдолтой.
- Мөн шинэчлэн сайжруулсан хөтөлбөрт орчуулгын дадлагыг хоёр удаа 2 кредиттэй хийдэг байхаар тусгаж өгсөн нь орчуулгын дадал чадвар өөрийн арга барилтай болоход чухал ач холбогдолтой юм.
- Суралцагчдын хятад хэлний түвшин тогтоох шалгалт өгөх үйл ажиллагааг дэмжих, чиглүүлэх, тогтмолжуулсан нь сайшаалтай.

### **1- р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

#### **2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Хичээлийн хөтөлбөрийн кредитийн бүтцийн судалгаа хийсэн.
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд шинжилгээ хийсэн бөгөөд хичээл хоорондын уялдааг судлагдахуун тус бүрээр нь товчоолон гаргасан бөгөөд энэ хичээлийн агуулгын залгамж холбоог хангах талд анхааран төлөвлөсний үр дүнд мэдлэг, чадварыг цогц байдлаар,

системтэй эзэмших боломжийг оюутнуудад бүрдүүлж өгсөн байна.

- Хөтөлбөрийг ОТИС мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн бүтцийн журмын дагуу бичсэн бөгөөд үр дүнд суурилсан хөтөлбөр хэмээн үзэж, сургалтын агуулга, аргазүй, технологи, үнэлгээ орчин нөхцөлийг хөтөлбөрийн үр дүнг бий болгоход чиглүүлж, хөтөлбөрийн стандартыг 2017, 2019 онуудад шинэчлэн боловсруулж, хичээл сургалтдаа ашиглаж байна.
- Сургалтын төлөвлөгөөний хичээл хоорондын холбоосыг харуулсан схем хийсэн.
- Суралцагч системээр дамжуулан суралцагч суралцахуйн үйл ажиллагааг төлөвлөдөг
- Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгааг хийж кредит цагийн задаргааг улирлаар нэгтгэсэн дүнг, суралцах сонголтын боломжийг харуулсан зураглал гаргасан.
- Удирдлагын мэдээллийн “ONEMIS” программ шинэчлэгдсэн. Мөн [www.otgontenger.mn](http://www.otgontenger.mn) –ийг тогтмол ажиллуулдаг байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага**

- БНХАУ-ын засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрүүд болон ОТИС-тай хамтын ажиллагаатай гадаадын их сургуулиудад урт, богино хугацааны тэтгэлэгт хөтөлбөрүүдэд хамрагдан суралцах боломжтой болсон. Мөн 2+2 хөтөлбөр хэрэгжүүлдэг. Күнзийн институтийн нэрэмжит тэтгэлгээр магистрын сургалтад тодорхойлон суралцуулж байна.

#### **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургалтын CDIO болон идэвхтэй сургалтын аргыг түлхүү хэрэглэж, орчуулгын хичээлд уламжлалт аргаас хамтарсан, харилцааны арга ашиглаж эхэлсэн байна.
- Сургалтын аргазүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмжтэй.
- Тодорхой нэг хичээлээр суралцахуйн үр дүнгүүд тэдгээрт хүргэх сургалтын аргазүйг өндөр түвшинд тодорхойлсон байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл:**

- Багш нарыг сургалт аргазүйн сургалтад байнга суулгаж хөтөлбөрөө шинэчлэхэд нь бэлддэг.
- Оюутан төвтэй, бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн, оюутан бүрийн идэвх оролцоог хангахад чиглэсэн, харилцаанд тулгуурласан сургалтын арга зүйг ашигладаг нэг жишээ нь бичих дадлын хичээл дээр хамтран суралцахуйн аргыг ашиглаж ирснээс харагдаж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Суралцагч төвтэй сургалтын арга зүйг бүх орчуулгын хичээлээс гадна хэлний чадвар олгох бусад хичээл дээр ашигладаг талаар тайланд тодорхой дурдаагүй.

#### **Зөвлөмж:**

- Гадаад хэлний орчуулга, заах аргазүйн талаарх орчин үеийн арга зүйн талаарх ном, товхимол, зөвлөмжийн хангамжийг сайжруулах, суралцагч төвтэй сургалтын арга зүйг бүх орчуулгын хичээлээс гадна хэлний чадвар олгох бусад хичээл дээр ашиглах.

### **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргазүйн судалгаа. Рубрик аргыг хүснэгтээр оруулж өгсөн байна.
- Явцын болон төгсөлтийн шалгалтын журамтай. /“Отгонтэнгэр Их Сургуулийн бакалаврын сургалтыг зохион байгуулахад баримтлах журам”/
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлтийг хийсэн.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлтийг нарийн дэлгэрэнгүй хийсэн.

**2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

### **3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургалтад хэрэглэгдэж байгаа анги танхим, лабораторийн хүртээмж сайн.
- Янз бүрийн чиглэлээр оюутанд үйлчилгээ үзүүлэх төвүүдтэй.
- Нэг оюутанд ноогдох талбай хангалттай, сургалтын тоног төхөөрөмжийн хангалт харьцангуй сайн.
- Холбогдох сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийдэг.
- Хичээлийн бус цагаар оюутан сургууль дээр байх орчин нөхцөлийг тогтмол сайжруулж байгаа.
- Унадаг дугуйн зогсоол хийсэн.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Дуу бичлэгийн студитэй
- Оюутны радио узельтэй
- Дугуйн зогсоолтой

**3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургалтад хэрэглэгдэж байгаа техник хэрэгсэл, интернэт үйлчилгээний талаар тогтмол судалгаа хийж, судалгааны мөрөөр шаардлагатай ажлуудыг хийж байна.
- Сургалтад хэрэглэгдэх ном, сурах бичгийн хүрэлцээ, хүртээмж сайн.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Зөвлөмж:**

- Багш нар хичээл сургалтдаа зориулж ном, сурах бичиг, гарын авлага хийхэд сургуулиас дэмжлэг үзүүлэх

**3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- ОТИС-ийн стратеги төлөвлөгөөндөө номын сан, мэдээллийн технологийн хөгжлийн дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна.
- Ном, сурах бичгийн төрлийг байнга баяжуулдаг.
- Номын сангийн үйл ажиллагаа, ном сурах бичгийн хүртээмжийн талаар сэтгэл ханамжийн судалгаа тогтмол хийдэг.
- Монголын Номын Сангуудын Консорциумын гишүүн болж, зарим цахим мэдээллийн санг үнэ төлбөргүй ашиглаж байгаа нь багш, суралцагсдад эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх боломжоор хангасан.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл:**

- Мини номын сантай.
- Хоёр салбар номын сантай бөгөөд ерөнхий эрдмийн хичээл, мэргэжлийн хичээлд хэрэглэгдэх ном оюутан бүр хангалттай.
- Зохиогчийн эрхийг дээдэлдэг сургууль болох зорилт тавьж, хуулбарлаж хувилсан номыг огт хэрэглэдэггүй.
- Цахим номын сан ажиллуулдаг бөгөөд нийт 800 гаруй номыг зохиогчийн эрхтэйгээр цахим номын сандаа байршуулжээ.
- Монголын Номын Сангуудын Консорциумын гишүүн болж, зарим цахим мэдээллийн санг үнэ төлбөргүй ашигладаг.

### **3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчныг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

#### **4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн багш нарын ажлын төлөвлөгөө тайлан, тэнхимийн төлөвлөгөө тайлан, хөтөлбөрийн дэд хороонд оруулах санал, хурлын протокол, оюутны сэтгэл ханамжийн судалгаа, төгсөгчийн ажил эрхлэлтийн судалгаа зэргийг цаг хугацаанд нь тогтмол хийдэг.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж (тэнхим) эхний улирлын эцэст хагас жилийн тайланг тэнхимд, хичээлийн жилийн төгсгөлд жилийн ажлын тайлангаа

сургуулийн хэмжээнд хэлэлцдэг. Тэнхим 1 хичээлийн жилээр ажлын төлөвлөгөө боловсруулдаг.

- Оюутнаас тухайн хөтөлбөр болон хэрэгжүүлэгч багштай холбоотой гомдол санал сүүлийн 5 жилд гараагүй. Бусад шалтгаанаар (чөлөө авах, төлбөр гм) гаргасан хүсэлт, өргөдөл байсан. Өргөдөл, хүсэлт бүртэй танилцав.
- 2013 оноос удирдлагын мэдээллийн системийг хөгжүүлэх үүднээс ONEMIS мэдээллийн нэгдсэн систем хэрэглэж ирсэн. 2019-2020 хичээлийн жилээс кредит системд шилжиж эхэлсэн. Албан ёсны 5 веб хаяг ажиллуулж, хөтөлбөрийн удирдлага, багш, суралцагчид тогтмол ашигладаг.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Туршлага:**

- Өргөдөл гомдол авах, шийдвэрлэх үйл ажиллагааг хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж, Сургалтын нэгдсэн алба, ЗХШҮА, салбар сургуулийн ёс зүйн хороо хариуцдаг.
- Маркетингийн алба нь ОТИС-ийн талаарх нэгдсэн мэдээлэл хэлбэрээр биш 18 хөтөлбөр тус бүрээр сурталчлах үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

#### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- 2002 оноос Тайваны Мин Чуаны их сургууль, 2014 оноос Ляо-Нингийн ИС, 2014 онд SIAS ОУ-ын дээд сургууль, 2015 оноос Жилинь Хуа Чяо гадаад хэлний ИС зэрэг хятадын их дээд сургуультай 2+2 хөтөлбөр, урт богино хугацааны сургалт, дадлага, ахисан түвшний тэтгэлэгт хөтөлбөр, сургалт зэргээр хамтран ажилладаг. Тайваны Мин Чуаны ИС-тай оюутан болон багш нарын ЭШ-ийн ажил зохион явуулдаг. Багш, суралцагчдын солилцоо, тэтгэлэг хөтөлбөрт хамрагдсан тоон судалгаагаар 16 оюутан, 16 төгсөгч, 2 багш хамрагджээ.
- Дотооддоо МУИС-ийн Күнзийн институт, МУБИС-ийн Күнзийн институт, Монголд суугаа Хятадын ЭСЯ, Тайваны худалдаа, эдийн засгийн төлөөлөгчийн газар, Хятад хэлний орчуулагчдын холбоо, Хятадын бизнес эрхлэгчдийн холбоо зэрэг байгууллагатай хамтран ажилладаг.

- Хятад сайн дурын болон мэргэжилтэн багш сүүлийн 5 жил тасралтгүй тус нэгжид ажиллажээ.
- Нийгэмд үзүүлсэн үйл ажиллагаанд: Genius орчуулгын товчоо болон хятад хэлний анхан, дунд шатны 3 сарын сургалтыг хямд төлбөрөөр тогтмол явуулдаг. Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн оюутнууд орчуулгын товчоонд дадлага хийж, тайлангаа хамгаалдаг.
- ОТИС-ийн төгсөгчдийн холбоо өөрийн гэсэн фэйсбүүк групптэй, үйл ажиллагаа нь тогтмолжсон байна. Тус холбооны УЗ-д хятад хэлний төгсөгч Мичидмаа байдаг. Төгсөгчидтэй байнгын эргэх холбоотой ажилладаг.
- Төгсөгчдийн 40% орчим нь БНХАУ, Тайванын их дээд сургуулиудад ахисан түвшинд суралцсан байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл:**

- Орчуулгын дадлага 1,2-ыг Genius орчуулгын товчоо, Кино орчуулга хийж гүйцэтгэдэг нь дотоод бааз, нөхцөл бололцоогоо түшиглэжээ.
- 2019 онд МУИС-ийн Күнзийн институттэй хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.

#### **Анхаарах асуудал:**

- Ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг их, дээд сургуультай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, багш нарын ЭШХ-д оролцох, оюутны тэмцээн уралдаанд оюутнаа сайн оролцуулах талаар анхаарах.

#### **Зөвлөмж:**

- Аман орчуулгын дадлага хийх явдлыг нэмэгдүүлэхтэй холбоотой гаднын байгууллагуудад хийх дадлагыг эрчимжүүлэх.
- Гаднын байгууллагатай хийх дадлагаа баталгаажуулах үүднээс гэрээ байгуулдаг болох.
- Гадаад оюутныг өөрийн сургуульдаа суралцуулах ажлыг эрчимжүүлэх.

### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж шууд захиран зарцуулах эрх мэдэл бүхий эрхзүйн зохицуулалт байхгүй салбар тэнхим нь үйл ажиллагааны төсөв боловсруулж батлуулдаг нэгдсэн байдалтай.
- Хичээлийн жил бүрийн орлого, зарлагын тайлангаас харахад багш, оюутанд чиглэсэн үйл ажиллагаанд төсвөөс ихээхэн зарцуулагддаг байна.

- Хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх гол хүчин болох багш нарыг сурч боловсрох, зэрэг ахих, гадаад дотоод сургалт, ЭШ хурал семинарт оролцох, эрүүл мэндийн асуудал зэрэгт мөнгөн тусламж үзүүлдэг.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч оюутанд Үүсгэн байгуулагч, Төгсөгчийн нэрэмжит тэтгэлэг, орон нутгийн оюутан, БЗД-ийн оюутан, хөдөө орон нутагт очиж амрах замын зардал олгохоос гадна бусад зарласан тэтгэлэгт хамрагдахад дэмжлэг үзүүлдэг байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багш, оюутны бие бялдар, эрүүл мэндийг хамгаалах, сайжруулахтай холбоотой бялдаржуулах, сэтгэл зүйн төв зэрэг өрөөтэй.
- Багш, оюутны хүүхдүүдийг асрах Одтой жаалууд цэцэрлэгтэй.

#### **Анхаарах асуудал:**

- Багш нар сургалтад ашиглах гарын авлага, ном сурах бичиг бичих, хэвлүүлэхэд сургуулийн зүгээс санхүүгийн дэмжлэг үзүүлэх

#### **Зөвлөмж:**

- Багш нарыг тогтмол хугацаанд эрүүл мэндийн үзлэгт хамруулах явдлыг тогтмолжуулах /2-3 жил тутамд/
- Багш нар гаргасан бүтээлдээ Оюуны өмчийн эрх /зохиогчийн эрх гм/ авах асуудлыг сайжруулах.

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Төгсөгчдийн судалгаа, ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаа зэргийг тогтмол авдаг.
- Тус сургууль нь “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах зорилгоор “Career center”-ийг 2019-2020 оны хичээлийн жилээс нээн ажиллуулж байна.
- Хөтөлбөрийг сурталчлан таниулах зорилгоор БЗД-ийн ЕБС-ийн сурагчидтай уулзалт ярилцлага, боловсролын үзэсгэлэн яармаг, сонин хэвлэл, ТВ ашиглан сурталчлах болон Нээлттэй хаалганы өдөр зохион явуулдаг байна.
- Ирмүүн агентлагтай хамтран “CosmoStudent” сэтгүүл гаргаж олон нийтэд таниулан сурталчлах үйл ажиллагаа явуулдаг.



- Мөн 2014-2015 оны хичээлийн жилээс “brand book” буюу ОТИС-ийн ном, лого бүхий бал, тэмдэглэлийн дэвтэр, малгай, фудболк зэргийг үйлдвэрлэж сургууль сурталчлах ажлыг хийж эхэлсэн. Энэ бүгдийг ОТИС-ийн Маркетингийн албатай хамтардаг.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл:**

- Төгсөгчдийг давтан сургах сургалт явуулж гэрчилгээ олгодог. Жилд ойролцоогоор 10-аад төгсөгч хамрагддаг.
- Орчуулгын дадлага /киноны орчуулга/ зэргээ давтах, хамгаалах Мультимедиа кабинеттай.

#### **Анхаарах асуудал:**

- Элсэгчдээс ОТИС-ийг яагаад сонгох болсон, тухайн хөтөлбөрийн талаарх мэдээллийг хаанаас хэрхэн авсан талаарх судалгааг авч сурталчилгааны аль хэлбэр үр дүнтэй байгаад дүн шинжилгээ хийж хэвшүүлэх.

#### **Зөвлөмж:**

- ОТИС дотроо давхар мэргэжлээр сурч төгсөх /хавсарга мэргэжил/ ажлыг эрчимжүүлэх. Одоо үед хятад, англи, солонгос хэлтэй эрх зүйч, сэтгүүлч, агаарын тээврийн үйлчлэгч г.м давхар мэргэжилтэй хүний эрэлт хэрэгцээ өссөн. Төгссөн үед ажил эрхлэлт нэмэгдэнэ.

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Тус хөтөлбөр тусдаа веб сайт хөтөлдөггүй бөгөөд [www.otgontenger.edu.mn](http://www.otgontenger.edu.mn) хэмээх сургуулийн үндсэн сайтад бүх мэдээлэл байршдаг байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхим Маркетингийн албаар дамжуулан мэдээллээ цаг тухайд нь хүмүүст хүргэдэг байна. ОТИС-ийн веб хуудастай танилцсан. Тухайн хөтөлбөртэй холбоотой мэдээллийг бүрэн авч болохуйц байна.
- Удирдлагын мэдээллийн “ONEMIS” программ шинэчлэгдсэн. Мөн [www.otgontenger.mn](http://www.otgontenger.mn) –ийг тогтмол ажиллуулдаг байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Элсэгчдийн 70-аад хувь нь БЗД-ийн байна. (20 хувийн хөнгөлөлт олгодог)

## **Анхаарах асуудал:**

- Сургууль, мэргэжил сурталчилгаа хийх арга хэлбэр олон, Маркетингийн хувьд боломжит ажлыг хийсээр байтал элсэлт төдийлөн сайн биш байгааг анхаарах.

## **4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

#### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ОТИС-д оюутан элсүүлэх журам болон холбогдох бусад дүрэм журмыг баримтлан оюутан элсүүлж байна.
- Шинээр элсэгчдэд зориулсан хөтөлбөр танилцуулах, сургуулиа сурталчлах мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон цахим орчноор байнга хүргэдэг.
- Элсэгч болон суралцагчдын бүртгэл судалгааг хийж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж ажилладаг.
- Элсэгчдийн болон бүртгүүлэгчдийн тоо, элсэгчдийн дундаж оноонд харьцуулсан судалгаа тогтмол хийдэг.
- Шинээр элсэгчдэд зориулан сургалт зохион байгуулдаг.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл:**

- Шинээр элсэгчдэд зориулсан хөтөлбөр танилцуулах, сургуулиа сурталчлах ажлыг сайн хийдэг.
- Шинээр элсэн орсон оюутнуудад зориулсан сургалтыг олон хэлбэрээр зохион байгуулдаг.
- Тус хөтөлбөрийн элсэгчдийн дундаж оноо ОТИС-ийн дундаж онооноос өндөр байна.

#### **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол,

чанартай үзүүлдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Суралцагчдад чиглэсэн үйлчилгээний ажлыг сайжруулах, оновчтой болгох тал дээр тодорхой зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.
- Оюутанд сургалтын болон чөлөөт цагийн үйлчилгээ үзүүлдэг нэгжүүд өөр өөрийн ажил үүргийн чиглэлээр ажилладаг.
- Оюутанд чиглэсэн сургалт, арга хэмжээ, клуб, дугуйлангийн үйл ажиллагааг сайн явуулдаг. Тус мэргэжлээр суралцаж байгаа оюутнууд мэргэжлийн дугуйланд хамрагдаж, хятад хэлний түвшин тогтоох шалгалт өгч, мэргэжлийн уралдаан тэмцээнд оролцох бэлтгэлээ хангаж байна.
- Оюутанд эрүүл мэндийн зөвлөгөө өгөх, анхан шатны тусламж үзүүлэх эмч ажилладаг.
- Сэтгэл зүйн үйлчилгээний төв ажиллаж, оюутан хүсвэл сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг. Гэхдээ энэ төв үйл ажиллагаагаа эхлээд удаагүй байгаа.
- Хууль зүй, клиник сургалтын төвд хандан оюутнууд хууль, эрх зүйн зөвлөгөө авах боломжтой.
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв ажилладаг.
- Оюутанд үйлчилгээ үзүүлдэг нэгжүүдийн талаарх сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийж, судалгааны дүнд дүн шинжилгээ хийж үйл ажиллагаандаа тусгадаг.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл:**

- Оюутанд үйлчилгээ үзүүлдэг нэгжүүдийн бүтэц, зохион байгуулалт, ажил үүргийн хуваарь маш тодорхой.
- Оюутанд зөвлөн туслах, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, график гарган ажилладаг.
- Дугуйлан, клубуудын нэгдсэн нээлтийн ажиллагааны өдөртэй болж, дугуйлангийн зорилго, ач холбогдлыг танилцуулан, сурталчлах ажил хийдэг.
- Дугуйланд хамрагдсан оюутны тоо байнга өссөн байна.
- Мэргэжлийн болон хувь хүний хөгжилд чиглэсэн сургалтуудыг тогтмол зохион байгуулж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Зарим төвүүдийн үйл ажиллагаа тогтмол биш. Нийт хэдэн багш, оюутан үйлчлүүлдэг талаар тодорхой баримт тайлан байхгүй.

#### **Зөвлөмж:**

- Зарим төвүүдийн үйл ажиллагаа тогтмолжуулах шаардлагатай. Тухайлбал, фитнес төвөөр багш, оюутнуудын хэдэн хувь нь үйлчлүүлдэг, нэг удаад хэдэн хүнд үйлчлэх боломжтой гэх мэт тоо баримтын тайлан хийх шаардлагатай.

### **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Оюутнууд оюутны холбоо болон бусад клубээр дамжин олон нийтийн болон сайн дурын үйл ажиллагаанд оролцож байна.
- Оюутны холбоо нь холбогдох дүрэм журмын дагуу тогтмол үйл ажиллагаа явуулдаг. Зохион байгуулсан үйл ажиллагаа болон санхүүжилт, зарцуулалтын талаар тухай бүрд нь танилцуулдаг.
- ОТИС- ийн жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд оюутны олон нийтийн болон бусад ажлын санхүүжилтийг тусган баталдаг.
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг сайжруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулсан, үүний илрэл нь төгсөгчийн нэрэмжит тэтгэлэг олгодог болсон байна.
- Уралдаан тэмцээнд амжилт гаргасан, идэвхтэй оролцсон оюутнуудад сургуулийн зүгээс тодорхой хэмжээний тэтгэлэг урамшууллыг байнга олгодог.
- Оюутнуудын олон нийтийн оролцоо, урамшууллын талаар тайлан мэдээ тогтмол хийдэг.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл:**

- Оюутны байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих санхүүжилт тогтмол өссөн байна.
- Мэргэжлийн буюу хятад хэлний олимпиад, уралдаан тэмцээнд оюутнууд тогтмол оролцдог.
- Сургуулийн зүгээс үзүүлж буй тэтгэлэг урамшууллын хэлбэр харьцангуй олон, тухайлбал Д.Оюунхорол гишүүний хөнгөлөлт, онцын хөнгөлөлт, орон нутгийн 20%, Баянзүрх дүүргийн 15%-ийн хөнгөлөлт гэх мэт.

#### **Анхаарах асуудал:**

- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оюутнууд бага оролцдог.

**Зөвлөмж:**

- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оюутнуудыг оролцуулах тал дээр анхаарч, идэвх оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй.

**5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- ОТИС-ийн бакалаврын сургалтыг зохион байгуулах журамд үндэслэн оюутны шилжилт хөдөлгөөнийг зохион байгуулдаг.
- Шилжилт хөдөлгөөний судалгааг тогтмол хийж, үр дүнг тооцдог.
- Шилжин ирж байгаа оюутнуудын багц цагийн дүйцлийг холбогдох дүрэм журмын дагуу хийдэг.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл:**

- Шилжилт хөдөлгөөний журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлэн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэдэг.
- Шилжилт хөдөлгөөний судалгаанаас харахад шилжилт хөдөлгөөн харьцангуй бага байна. Шилжиж явсан оюутны тоо харьцангуй бага, шилжиж ирсэн оюутны тоо харьцангуй их.

**5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

**Илрэл нотолгоо:**

- ОТИС-ийн “Оюутныг төгсгөх журам”, “Төгсөлтийн шалгалтын журам” зэрэгт үндэслэн төгсөлтийн үйл ажиллагааг зохион байгуулдаг.
- Төгсөлтийн баримт бичгийг батлагдсан дүрэм журмын дагуу олгодог.
- Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын хэрэгжилтэд сургуулийн дотоод хяналт, үнэлгээний алба зэрэг нь хяналт тавьж ажилладаг.
- Төгсөлтийн баримт бичигт оюутны мэргэшил, хөтөлбөрийн үр дүн, хувь хүний гүйцэтгэл, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Төгсөгч оюутны бичиж хамгаалсан дипломын ажил нь дипломын ажилд тавигдах шаардлагыг хангасан байна.

## **5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

#### **6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримт бичигтэй / 9 журам байна./ Эдгээр журмын хэрэгжилтийн тайлагнадаг.
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жингийн, судалгааг хийсэн. 2015-2020 оны байдлаар дундаж хувь 31,2 хувь болсон байна.
- Багш суралцагчдын тооны зохистой харьцааны судалгаагаар сүүлийн таван жилийн дунджаар нэг багшид оногдох оюутны тоо 20,7 байна.
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг ба зэрэглэл нь профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багш гэсэн ангилалд хуваагддаг.
- Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа хийгдсэн. Сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгч, дадлагажигч багшаас бусад багш нарт нэг хичээлийн жилд 28 багц цаг байна.
- Оюутны тоо харьцангуй цөөн тул багш оюутны тооны харьцаа зохимжтой, багш нарын хувьд оюутантай тулж ажиллахад боломжтой.
- Багш нар жил бүр багшлах болон бусад ажлын хувийн төлөвлөгөө гаргаж ажилладаг, үүний хэрэгжилтийн дагуу цагийн ноогдлын биелэлт болон бусад ажлаа үнэлүүлж дүгнүүлж хэвшсэн.
- ОТИС-ийн хэмжээнд зохих журмын дагуу багш нарт үр дүнгийн урамшуулал олгодог

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл:**

- Багш нарт олгосон урамшууллын судалгааг хийсэн байна.
- Багш нар сургалтын төлбөр, хүүхэд, гэр бүлийн сургалтын төлбөр, цэцэрлэгийн сургалтын төлбөрөө хөнгөлүүлж, тэтгэмж, тусламж эдэлжээ.

## **6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа, судалгааны дагуу ОТИС-ийн багшийн чадамжийг гаргаж, төлөвлөгөө боловсруулсан.
- Төлөвлөгөөг гаргасан, тайлан хийсэн байна.
- Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгааг хийсэн. 2015-2016 оны хичээлийн жилд хятад хэлний 3 багш БНХАУ-д ахисан түвшний сургалтад суралцахаар болжээ. Тэнхимийн нийт 5 багш гадаадын их сургууль, доктор магистрын зэрэгт суралцаж, 2 багш төслийн сургалтад сууж ОУ-ын сургалтын гэрчилгээ авсан. 1 багш англи хэлний хөтөлбөрт амжилттай хамрагдаж байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багш хөгжлийн төвийг ажиллуулж багш нарын англи хэл, заах аргазүйн сургалтыг явуулдаг.
- Эрдэм шинжилгээний төв ажиллуулж багшийн эрдэм шинжилгээний ажлыг дэмжих үйл ажиллагаа явуулж байна.

## **6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Бодлогын баримт бичиг, дүрэм журам боловсруулсан.
- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээ, хөтөлбөрт тусгагдсан бөгөөд 5 жилийн хугацаанд 12 төсөлд оролцогч, зохицуулагчаар ажилласан байна.
- Зарцуулсан төсөв, тайланг тайланд тодорхой тусгасан байна.

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багш нар орчуулгын төсөл, захиалгат гэрээт орчуулгын бүтээлүүд хийсэн.
- Багш оюутны хамтарсан орчуулгын бүтээлийн эмхэтгэл гаргадаг.
- Тайлант хугацаанд багш нарын мэргэжлийн чиглэлээр, дотоодын сургалт, семинарт мэргэжил дээшлүүлсэн байна.

#### **Анхаарах асуудал:**

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инновац, ашигтай загвар, патентын тоон судалгаа огт байхгүй.
- Гадаадын судалгааны сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлийн тоо цөөн.
- Хэрэгжүүлсэн судалгааны төсөл цөөн.
- Судалгааны ажлаас эшлэгдсэн тоон үзүүлэлт байхгүй.
- Гадаадын мэргэжлийн холбоодын гишүүн болсон багшийн тоо цөөн.

#### **Зөвлөмж:**

- Бүх багш нар гадаад дотоодын мэргэжлийн холбоодод гишүүнчлэлтэй болох.
- Багшийн эрдэм шинжилгээ судалгааны ажлын гол үр дүн болох өгүүлэл, монограф, олон улсын болон улсын хэмжээний хурал, форумд оролцох оролцоог нэмэгдүүлэх.
- Багш нарын судалгааг ОУ-ын импакт фактор өндөртэй сэтгүүлд хэвлүүлэх тал дээр анхаарч, дэмжин, импакт фактор өндөртэй сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх сургалтыг сургуулиас явуулах хэрэгтэй байна.
- Зохиогчийн эрхийн гэрчилгээтэй болох.
- Орчуулгын олон хичээлдээ гарын авлага, сурах бичиг бичих.
- Орчуулга зүйн чиглэлийн онол практикийн талаар судалгааны ажил хийх.
- Судалгааны төсөл хэрэгжүүлэх шаардлагатай.
- Эрдэм шинжилгээний төвийн багшийн эрдэм шинжилгээний ажлыг дэмжих үйл ажиллагааг сайжруулах.

#### **6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Багш өөрийн үнэлгээний тайланг 5 жил тутам бичиж хөндлөнгийн үнэлгээ хийлгэдэг.



- Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх дүгнэх журмыг хэрэгжүүлж хэрэгжилтийг аттестатчиллаар дүгнэдэг.
- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний тайлан хийсэн.
- Багшийн хавтас хөтөлж , шинэчилж сайжруулдаг.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Туршлага:**

- Сургуулийн хэмжээнд сургалтын үйл ажиллагаандаа ISO 9001 стандартыг 2016 оноос эхлэн нэвтрүүлэхээр ажиллаж 2018 онд амжилттай нэвтрүүлсэн.
- Эрдэм шинжилгээ буюу Б цагийг тогтоосон хэмжээнээс илүү хийсэн тохиолдол 4-6 кредиттэй тэнцэх урамшуулал олгодог.

### **6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

##### **7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

#### **Илрэл нотолгоо:**

- 2012 оноос тус сургууль нь дотоод хянан шалгалт, чанарын дотоод баталгаажуулалтын журам боловсруулсан. Үүнтэй холбоотой шинээр мэргэжилтний орон тоо бий болгосон.
- MNS ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлсэн.
- Хөтөлбөрийн ерөнхий хороо, дэд хороог байгуулан ажилласан.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- MNS ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлж багш нарт сургалт зохион явуулж, гарын авлага гаргасан.

##### **7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны

болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

#### **Илрэл нотолгоо:**

- Оюутны сэтгэл ханамжийн судалгааг тогтмол жил бүрийн 12 сард авдаг. 18 асуулттай байсныг 8 бүлэг 42 асуултаар авдаг болжээ.
- Багш ажилчдын социологийн судалгааг тогтмол авдаг.
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг 12, 6 сард авч, уламжлал болгосон. Судалгаа авсны дараа 7, 1 сард дэд хороо, багш нарт үр дүнг мэдээлдэг.
- Ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авдаг. 2020 оны байдлаар 50 орчим хувь мэргэжлийн ур чадвар сайжруулах сургалт шаардлагатай, 33 хувь нь ямар нэг сургалт явуулах шаардлагагүй гэж дүгнэжээ.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Туршлага:**

- Төгсөгчдийн 25 хувь нь БНХАУ-д ахисан түвшинд суралцдаг.
- Отгонтэнгэр их сургуулийн сургалтын хэрэглэгдэхүүн, судалгааны ажилд тавих ерөнхий шаардлага CS11-0413:2018 боловсруулсан. Ангийн ажил, дипломын ажил, гарын авлага, ном сурах бичигт тавигдах шаардлагыг нарийвчлан тусгасан.

#### **Анхаарах асуудал:**

- Ажил эрхлэлтийн судалгаанаас харахад **мэргэжлийн бус ажил хийж байгаа**, үргэлжлүүлэн сурч байгаа болон мэргэжлээрээ ажиллаж байгаа гэсэн 3 дараалал хамгийн их хувийг эзэлж байна.

#### **Зөвлөмж:**

- Орчуулгын дадлагыг аль болох гаднын байгууллагад хийж, үргэлжлүүлэн ажиллах явдлыг нэмэгдүүлэх.

#### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Гадаад хэлний орчуулга /хятад хэл/ хөтөлбөрийг өмнө нь 2014-2015 оны хичээлийн жилд БМИҮЗ-өөр магадлан итгэмжлэгдсэн. Одоо 2 дахь удаагаа орж байна.
- Мэргэжлийн холбоотой хамтран ажиллах байдал хангалттай байна.

- Ажил эрхлэлтийн хувьд төгсөгчдөөс 6 сарын дараа эхний судалгаа авахад 20% ажилд орсон, 2 жилийн дараа дахин судалгаа авахад энэ хувь нэмэгдсэн байна.

### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Онцлог зүйл/Туршлага:

- Тус хөтөлбөрөөр төгссөн оюутнуудаас 1 оюутан ОТИС-д хэлшинжлэл мэргэжлээр үргэлжлүүлэн сурч магистр хамгаалсан. Одоо нэг оюутан ахисан шатанд сурч байна.

#### Зөвлөмж:

- 2019 онд хөтөлбөрөө шинэчлэн Орчуулгын дадлага 1-6 хичээлийг тодорхой мэргэжлээр мэргэшүүлсэн болгож өөрчилсөн. /аялал жуулчлал, эрүүл мэнд, бизнесийн, уран зохиолын гм/. Тиймээс эдгээр салбарт ажиллах сайн орчуулагчдыг бэлтгэж, зах зээлд сургуулийн нэр хүндийг өсгөх, мэргэжлээ сурталчлах.

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

### ДҮГНЭЛТ

ОТИС-ийн Гадаад хэлний орчуулга /Хятад хэл/ хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

Шалгуур	Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан
1 Хөтөлбөрийн төлөвлөлт	3	0	0	Бүрэн хангасан
2 Сургалтын үйл ажиллагаа	3	0	0	Бүрэн хангасан
3 Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3	0	0	Бүрэн хангасан
4 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5	0	0	Бүрэн хангасан
5 Суралцагчид чиглэсэн үйл	5	0	0	Бүрэн хангасан

6	Багшийн үйл ажиллагаа	3	1	0	Бүрэн хангасан -Хөтөлбөр хариуцагч багш нар эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлээр оюуны өмчийн эрх, инновац, ашигтай загвар, патент аваагүй. -Багш нарын илтгэл, өгүүлэл зөвхөн сургуулийн хэмжээнд тавигдаж нийтлэгдсэн. Тоо хэмжээ цөөн. -Багш нар гадаад, дотоодын мэргэжлийн холбоодын гишүүнчлэлгүй.
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	3	0	0	Бүрэн хангасан
		25	1	0	
<b>Дүгнэлт</b>		<b>Бүрэн хангасан</b>			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Отгонтэнгэр сургуулийн Хүмүүнлэгийн сургуулийн “Гадаад хэлний орчуулга /Хятад/ бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Урлаг, хүмүүнлэгийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

### НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

<b>Сургуулийн нэр</b>	ОТИС, Хүмүүнлэгийн сургууль
<b>Хөтөлбөрийн нэр</b>	Гадаад хэлний орчуулга /Хятад хэл/
<b>Хөтөлбөрийн индекс</b>	023101
<b>Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Европ, Америк, БНХАУ-аас бусад Азийн их дээд сургуулиудын ижил төстэй, хятад хэлний орчуулагч бэлддэг хөтөлбөрүүдтэй харьцуулах үзэх шаардлагатай.</li> <li>- Зөвхөн хичээлийн нэр төрлийн түвшинд бус, хичээлийн хөтөлбөрийн агуулгыг харьцуулсны үндсэн дээр сургалтын хөтөлбөрөө улам сайжруулах тал дээр судалгаа хийх шаардлагатай байна.</li> </ul>

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>- Гадаад хэлний орчуулга, заах аргазүйн талаарх орчин үеийн арга зүйн талаарх ном, товхимол, зөвлөмжийн хангамжийг сайжруулах, суралцагч төвтэй сургалтын арга зүйг бүх орчуулгын хичээлээс гадна хэлний чадвар олгох бусад хичээл дээр ашиглах.</li> </ul>
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> <li>- Багш нар хичээл сургалтдаа зориулж ном, сурах бичиг, гарын авлага хийхэд сургуулиас дэмжлэг үзүүлэх</li> </ul>
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> <li>- Аман орчуулгын дадлага хийх явдлыг нэмэгдүүлэхтэй холбоотой гаднын байгууллагуудад хийх дадлагыг эрчимжүүлэх.</li> <li>- Гаднын байгууллагатай хийх дадлагаа баталгаажуулах үүднээс гэрээ байгуулдаг болох.</li> <li>- Гадаад оюутныг өөрийн сургуульдаа суралцуулах ажлыг эрчимжүүлэх</li> <li>- ОТИС дотроо давхар мэргэжлээр сурч төгсөх /хавсарга мэргэжил/ ажлыг эрчимжүүлэх. Одоо үед хятад, англи, солонгос хэлтэй эрх зүйч, сэтгүүлч, агаарын тээврийн үйлчлэгч гм давхар мэргэжилтэй хүний эрэлт хэрэгцээ өссөн. Төгссөн үед ажил эрхлэлт нэмэгдэнэ.</li> <li>- Багш нарыг тогтмол хугацаанд эрүүл мэндийн үзлэгт хамруулах явдлыг тогтмолжуулах.</li> </ul>
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> <li>- Суралцагчдын эрдэм шинжилгээ, судалгаа, бүтээлч байдлыг дэмжиж старт-ап компани байгуулах зэргээр эрдэм шинжилгээний ажлыг өргөжүүлэх.</li> </ul>
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>- Багш нар эрдэм шинжилгээний ажлаа эрчимжүүлэх, түвшингээ ахиулах, эрдмийн зэрэг хамгаалах, сургалт судалгааг уялдуулах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай.</li> <li>- Багш нар гаргасан бүтээлээ Оюуны өмчийн эрхийн гэрчилгээгээр баталгаажуулах, /зохиогчийн эрх гм/ гэрчилгээ авах асуудлыг сайжруулах.</li> </ul>

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> <li>- Орчуулгын дадлагыг аль болох гаднын байгууллагад хийж, үргэлжлүүлэн ажиллах явдлыг нэмэгдүүлэх.</li> <li>- 2019 онд хөтөлбөрөө шинэчлэн Орчуулгын дадлага 1-6 хичээлийг тодорхой мэргэжлээр мэргэшүүлсэн болгож өөрчилсөн. /аялал жуулчлал, эрүүл мэнд, бизнесийн, уран зохиолын гм/. Тиймээс эдгээр салбарт ажиллах сайн орчуулагчдыг бэлтгэж, зах зээлд сургуулийн нэр хүндийг өсгөх, мэргэжлээ сурталчлах.</li> </ul>
ШААРДЛАГА: /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал шаардлага бичнэ/	
Шалгуур 6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа	<ul style="list-style-type: none"> <li>- Багш нар гадаад дотоодын мэргэжлийн холбоодод гишүүнчлэлтэй болох.</li> <li>- Багшийн эрдэм шинжилгээ судалгааны ажлын гол үр дүн болох өгүүлэл, монограф, олон улсын болон улсын хэмжээний хурал, форумд оролцох оролцоог нэмэгдүүлэх.</li> <li>- Багш нарын судалгааг ОУ-ын импакт фактор өндөртэй сэтгүүлд хэвлүүлэх тал дээр анхаарч, дэмжин, импакт фактор өндөртэй сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх сургалтыг сургуулиас явуулах хэрэгтэй байна.</li> <li>- Зохиогчийн эрхийн гэрчилгээтэй болох.</li> <li>- Орчуулгын дадлага эзэмшүүлэх олон төрлийн хичээлдээ гарын авлага, сурах бичиг бичих.</li> <li>- Орчуулга зүйн чиглэлийн онол практикийн талаар судалгааны ажил хийх.</li> <li>- Судалгааны төсөл хэрэгжүүлэх шаардлагатай.</li> <li>- Эрдэм шинжилгээний төвийн багшийн эрдэм шинжилгээний ажлыг бодлогоор дэмжих, үр дүнг нэмэгдүүлэх.</li> </ul>

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг: ..... /Д.Ундрах/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг:..... /Б.Оюунчимэг/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг: ..... /Л.Чойжилмаа/

### **ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ**

1. Суралцагчдын эрдэм шинжилгээ, судалгаа, бүтээлч байдлыг дэмжиж старт-ап компани байгуулах зэргээр эрдэм шинжилгээний ажлыг өргөжүүлэх.

2. Багш нарын эрдэм шинжилгээний бүтээл, судалгааны ажлын эшлэгдсэн байдлыг дэмжихэд чиглэсэн профессорын манлайллыг дэмжин ажиллах.
3. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулах төсвийн зарцуулалтыг нэмэгдүүлэхэд гадаад, дотоодын хамтын ажиллагаатай байгууллагуудтай хамтран ажиллах, төсвийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглэн ажиллах.
4. Багш нарын судалгааг ОУ-ын фактор өндөртэй сэтгүүлд хэвлүүлэх тал дээр анхаарч, дэмжин, фактор өндөртэй сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх сургалт явуулах.
5. Орчуулгын дадлагын нэг хэсгийг аж ахуйн нэгж, байгууллагууд дээр хийдэг болох.

*“Болор софт” программ ашиглан алдааг хянав.*

#### IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

##### I. Багш нарын нэрс

№	Овог нэрс	Албан тушаал	Заадаг хичээл	Утас
1	Б.Энхбаяр	ХС-ийн захирал	Сэтгэл судлалын үндэс	88004016
2	Э.Номин	Тэнхмийн эрхлэгч	ЯБХД, Хятад орон судлал	88096423
3	Л.Хишигжаргал	Багш	ЯБХД, Бичгийн дадлага, Орчуулгын дадлага	99030940
4	Жан Жэньжэнь	Мэргэжилтэн багш	ЯБХД, Хятад хэл	88189264
5	Ө.Нарантуяа	багш	Орчуулгын дадлага, Ярианы дадлага	89065919
6	С.Одхүү	Багш	Хүний хөгжил, харилцааны ёс зүй, эрхзүй	
7	Г.Жаргалсайхан	Багш	МХБН	86135354
8	Ц.Өлзийхишиг	Багш	Англи хэл	88099516
9	С.Эрхэмбаяр	Багш	Менежментийн үндэс	99024415
10	Д.Мөнхбаатар	Багш	Мэдээллийн технологи	
11	Г.Золзаяа	Багш	Улс төрийн үндэс	80036333

##### II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас
1	Ж. Болортуяа	4-р анги		88174750
2	Н.Наранзул	4-р анги		80046138
3	Г.Содбилэг	4-р анги	Спортын Манлайлагч	98130045
4	Б.Сайнжаргал	4-р анги		88420919
5	Б.Сувд	3-р анги		91310314
6	Д.Цацрал	3-р анги		91279001
7	Я.Золбоо	3-р анги		88552391
8	Б.Тамжид	3-р анги	Орон нутгийн	89332393
9	Б.Номин-Эрдэнэ	1-р анги	Дотуур байранд амьдардаг	94691219
10	М.Мөнхзаяа	1-р анги		99729197

##### III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага, албан тушаал	Утас	Гарын үсэг
1	江志梅	ЕБ 23-р дунд сургуулийн хятад хэлний эрхлэгч	99263880	
2	Б.Батцэцэг	Күнз бага сургуулийн Гадаад хэлний менежер	80804733	
3	王丽	Хятадын хөрөнгө оруулалттай For you ХХК, Хятад талын захирал		
4	Л.Уранзаяа	Монгол ЛЗ зам гүүр ХХК, Хүний нөөцийн менежер	88557557	



5	Б.Ганбаатар	AGG орчуулгын товчооны захирал	96661545	
6	Гэрэл	“БЛЫЮ ГРАСС” ХХК, менежер	99128580	
7	Б. Цэцэгдэлгэр	China state Grid Nr electronic company Mongolia project manager	80119595	
8	Э.Бүрэнжаргал	Натурал текстайл төслийн менежер	99108073	

#### IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага, албан тушаал
1	Э.Мичидмаа	2017	Хувиараа бизнес эрхлэгч
2	П.Мөнх-эрдэнэ	2017	Дун фан махны үйлдвэр, орчуулагч
3	О.Авидбуу	2017	“Ри фөн “ ХХК –ы орчуулагч, хүний нөөцийн мэргэжилтэн
4	Ц.Нансалмаа	2018	"Юу шан тоузи" ХХК орчуулагч
5	Э.Тунгалагуяа	2018	Аялал жуулчлалын газарт хөтөч
6	С.Уртнасан	2020	НЗДТГазар, ажлын албаны ажилтан
7	М.Төрмөнх	2020	Их хүрд ХХК орчуулагч
8	Д.Аззаяа	2015	БНХАУ-д магистрт суралцаж байгаа
9	Энхсайхан	2015	Цагаан согсоот транслэйшн ХХК
10	Э.Алтансүх	2017	“Натурал Грасс Ланд” ХХК Өөх тос боловсруулах үйлдвэр Үйл ажиллагааны менежер

**V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**  
**/албан бичгийг оруулах/**



**ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛЬ**

13343 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Энхтайваны өргөн чөлөө, Жуковын гудамж,  
Утас: 7017 3933, 45 39 44, Факс: (976-11) 45 86 35, 46 35 48,  
И-мэйл: info@otgontenger.edu.mn,  
Вэбсайт: www.otgontenger.edu.mn

2021.06.14 № 2/49

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН**  
**ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ**  
**ЗӨВЛӨЛД**

Отгонтэнгэр их сургуулийн Гадаад хэлний орчуулга /хятад хэл/ бакалаврын хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийсэн шинжээчийн багийн тайлантай танилцан, шинжээчийн багийн тайланг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг цаашдын үйл ажиллагаандаа тусган ажиллах болно.

ЗАХИРАЛ \_\_\_\_\_ доктор, дэд.проф Н.ЭНХЗАЯА

